

## СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ, АШИГЛАХАД НУТГИЙН ИРГЭДИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЖ, ОРОН НУТГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН


“Соёлын өвийг хамгаалах, ашиглахад нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлж, орон нутгийг хөгжүүлэх системийн судалгаа” төслийн 2015 оноос эхлэн 4 дэх жилдээ амжилттай хэрэгжүүлж байгаа бөгөөд цаашид судалгаагаа өргөжүүлэн уламжлал болгохыг зорьж байна. Судалгааны үйл ажиллагаа нь:

1. Судалгаа
2. Сургалт
3. Үзэсгэлэн

Гэсэн гурван үе шаттай хэрэгжүүлсэн бөгөөд сургалт, судалгааны ажлын үр дүнгээр үзэсгэлэн зохион байгуулж түүний үйл ажиллагааг сайжруулан хөгжүүлэх зорилгоор үзэсгэлэнгийн агуулга тус бүрт нь ажиглалтын судалгаа хийхэд

“Орон нутгийн түүх соёл, аж амьдрал” сэдэвт түр үзэсгэлэнг сарын хугацаанд нийтийн хүртээл болгохын зэрэгцээ агуулга тус бүрт нь ажиглалтын судалгааг 860 үзэгчдийн дунд:

- Орон нутгийн түүхэн хөгжил
  - Орон нутгийн аж амьдрал
  - Уламжлалт тоглоом наадгай
  - Иргэдийн гар урлалын бүтээгдэхүүн зэрэг агуулгын хүрээнд явуулсан.
- Зургаар үзүүлбэл:



Дээрх зургаас үзэхэд уламжлалт тоглоом наадгай 39%, Орон нутгийн аж амьдрал 33%, гар урлалын бүтээгдэхүүн 26%, орон нутгийн түүхэн хөгжил 2% -ыг эзэлж байна. Судалгаанаас хархад хүмүүсийн дийлэнх хувь нь монголын ахуй амьдрал, гар урлалын бүтээгдэхүүн зэрэг үзмэрүүдийг шимтэн үзэж, гэрэл

зургаа татуулах, уламжлалт тоглоом наадгай тоглох аргыг нь заалгаж түүгээр тоглон тун сэтгэл хангалуун байдал ажиглагдаж байлаа.

## 2016 он

“Хархорины өв соёл” сэдэвт түр үзэсгэлэнг нэг сарын хугацаанд дэглэхдээ агуулга тус бүрт нь ажиглалтын судалгааг 1065 үзэгчдийн дунд:

- Цагаан идээ боловсруулах арга
- Арьс шир боловсруулах арга болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн
- Түүх соёлын дурсгалт газар
- Гар урлалын бүтээгдэхүүн зэрэг сэдвийн хүрээнд явуулсан. Судалгааг авахдаа үзмэр тус бүр дээр саатан, тогтож үзэх цаг минутыг авч үзсэн болно. Зарцуулсан хугацаа:
  - Нийт хугацаа: 70 цаг
  - Дундаж нь: 28 минутыг зарцуулсан байна/(53+4):2=28 минут / байна.


### Үзмэр үзэж саатах хугацаа

Хүснэгт№1

Үзмэр үзэж саатах хугацаа					
№	Цагаан идээ боловсруулах арга	Арьс шир боловсруулах арга /дээл өмсөх/	Түүх соёлын дурсгалт газар	Гар урлалын бүтээгдэхүүн	Нийт цаг,минут
1	22цаг 52минут	29цаг21минут	10цаг27минут	8цаг 47минут	70 цаг

Үүнийг зураглалаар үзүүлбэл:

### Үзэгчдийн саатах хугацаа



дээрх зургаас хархад арьс шир боловсруулах арга, түүгээр хийсэн дээл, хувцас 41%, цагаан идээ боловсруулах арга 32%, гар урлалын бүтээгдэхүүн 15%,түүх соёлын дурсгалт газар12%-ыг эзэлж байна.

### Нөлөөлөх нөхцөл:

Судалгаанд ямар хүчин зүйлүүд нөлөөлөж байна бэ? түүний мөрөөр цаашид хийж төлөвлөх арга замыг нарийвчлан тодорхойлох үүднээс дараах 4 хүчин зүйлийг гол болгов.

1. Үзэсгэлэнгийн байршил
2. Тайлбар хийж буй хүмүүс бусдад нөлөөлөх хүчин зүйл болон тайлбарлах мэдлэг чадвар
3. Хөтөч тайлбарлагчын мэдлэг чадвар, нөлөөлөх хүчин зүйл
4. Үзэгчидэд нөлөөлж буй хүчин зүйл зэргийг авч үзвэл:


Хөхүүртэй айраг, цагаан идээ, арьс шир боловсруулах арга, түүгээр хийсэн дээл хувцас зэрэг бодитоор дэглэсэн үзмэрүүдийг гэр бүл, хэсэг бүлгээр аялаж буй хүмүүс илүү их сонирхож амтлах, өмсөж зүүн зургаан авхуулах, гэрэл зураг авч сэтгэл хангалуун байлаа. Үүнд:

- Төсөлд оролцож буй хүмүүсээс цагаан идээ, дээл хувцас, гар урлалын зүйлсийн хийх арга уламжлалыг сайн танилцуулсан Тэгшжаргал, Банзрагч, Балжинням, Оюун, Ш.Алтанцэцэг, Л.Алтанцэцэг нар сонирхолтой тайлбар хийсэн бол, суран эдлэл, хөхүүр, арьс шир элдэх аргыг Хишигжаргал, Э.Лхагвасүрэн, Д.Лхагвасүрэн нар илүү сонирхолтой тайлбар хийсэн.
- Монголын хөтөч тайлбарлагчдын зарим нэг нь уламжлалт ахуйн эд зүйлсийнхээ хэрэглээний зориулалт, хийх аргыг мэдэхгүйгээс болж ерөнхий тайлбар хийж байгаа нь анзаарагдсан. Энэ нь үзэсгэлэн үзэж буй үзэгчдээс шууд анзаарагдаж байв.

“Хархорны өв соёл” сэдэвт түр үзэсгэлэнг сарын хугацаанд дэглэхдээ агуулга тус бүрт нь ажиглалтын судалгааг 1572 үзэгчдийн дунд явуулав.

#### Ажиглалтын судалгаа/2017.08.01-08.31/

№	Үзэсгэлэнгийн хэсгүүд	Саатсан хугацаа	Эзлэх хувь
1	Цагаан идээ боловсруулах арга технологи/Амталгаа/	1191 цаг	22.3%
2	Арьс шир боловсруулах арга технологи/Туршиж үзэх/	1213 цаг	23%
3	Уламжлалт тоглоом наадгай	1877 цаг	35.2%
4	Видео үзүүллэг	658 цаг	12.3%
5	Чөлөөт булан	387 цаг	7.2%



**Хархорины өв соёл-2** түр үзэсгэлэнгийн үзэгчдийн саатан үзсэн хугацааны хувьд авч үзвэл хамгийн дээд тал нь 50 минут дунджаар 30 минутын хугацаа зарцуулж цагаан идээ амталж, боловсруулах аргыг нь үзэж сонирхох, монгол дээл хувцас өмсөж үзэж зургаа авахуулах, монгол тоглоомоор наадах, тоглох арга барилаас суралцаж байв.

Үзэсгэлэнгийн үеэр үзэж сонирхсон үзэгчдийн талаар тэмдэглэл хөтөлсөн бөгөөд түүнд шинжилгээ хийж үзвэл нийт үзэгчдийн 76%-ийг гадаадын жуулчид эзэлж байгаагийн дотор Франц, Герман, Итали, Япон, Америк, Солонгосын жуулчид дийлэнх хувийг эзэлж байна.

#### **Нөлөөлөх нөхцөл:**

Судалгаанд ямар хүчин зүйлүүд нөлөөлж байна вэ? Түүнийг цаашид хөгжүүлэхэд тулгарч буй бэрхшээл арга замыг нарийвчлан тодорхойлох үүднээс дараах 4 хүчин зүйлийг гол болгов.

- Үзэсгэлэнгийн байршил болон сонирхол татсан үзмэрүүд
- Орон нутгийн тайлбарлагч нарын мэдлэг ур чадвар, бусдад нөлөөлөх зүйл
- Мэргэжлийн хөтөч тайлбарлагчийн мэдлэг, ур чадвар бусдад нөлөөлөх хүчин зүйл
- Үзэгчдийн анхаарал, сэтгэл хөдлөлийг татахад нөлөөлөх хүчин зүйл

#### **Дүгнэлт:**

2015-2017 оны сургалт, судалгааны ажлын үр дүнгээр 3 удаа үзэсгэлэн нэг сарын хугацаанд дэлгэн нийтийн хүртээл болгож, үзэсгэлэн үзэж сонирхсон аялагч жуулчдын сэтгэл ханамж болон тэдэнд нөлөөлөж буй хүчин зүйлсийг тогтоох зорилгоор ажиглалтын судалгаа хийсэн. Үүнд цагаан идээ болон арьс боловсруулах арга технологи, түүгээр хийсэн өрөм, ааруул, эзгий мөн дээл малгай, гутал зэрэг бодитоор дэлгэсэн үзмэрүүдийг гэр бүл, хэсэг бүлгээрээ аялаж буй хүмүүс илүү сонирхож амтлах, өмсөх, зураг авхуулах гэрэл зураг авах зэргээр сэтгэл хангалуун байлаа. Харин мэргэжлийн хөтөч

тайлбарлагчдын зарим нэг нь уламжлалт ахуйн соёлын эд зүйлс түүний хэрэглээ зэргийг мэдэхгүйгээс болж ерөнхий тайлбар хийж байгаа нь ажиглагдсан юм. Энэ нь үзэсгэлэн үзэж буй үзэгчдийн сэтгэлзүйгээс илт харагдаж байв. Түр үзэсгэлэнгийн агуулга тус бүрт хийсэн судалгааг хэрьцуулан үзэхэд нүүдэлчдийн соёл суурин соёлын нөлөөгөөр мартагдаж монгол ахуй амьдрал, аж төрөх ёс түүнийг сэргээн хөгжүүлэх хэрэгцээ шаардлага их байгааг илтгэж байна.